

Монгол Улсын Гадаад харилцаа ба Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагатай харилцах харилцаа

Э. Наран*

Оршил

2013 онд Монгол Улсын гадаад харилцаа идэвхтэй ажиллаж гадны улс орнуудтай өргөн хүрээнд харилцаж, өндөр дээд хэмжээний харилцан айлчлалуудыг хийж байсан боловч гадаад харилцааны гол төв нь Хятад Орос хоёр хөрш улс нь байлаа. Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын анхны ажиглагч орны хувьд Монгол Улс уг байгууллагатай харилцах харилцааг улам илүү чухалчилж байгаа юм, Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын (ШХАБ) хүрээн дэх эдийн засаг худалдаа, эрчим хүч, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хилээр дамжин өнгөрөх тээвэр, аялал жуулчлал зэрэг салбаруудын хамтын ажиллагаанд анхааралаа хандуулж байна.

1. Гадаад харилцаа

(1) Монгол Улсын гадаад харилцаа идэвхтэй ажиллав.

2013 онд Монгол Улсын гадаад харилцаа урьдын адил идэвхтэй ажиллав, Орос Хятад хоёр хөрш болон бусад “гуравдагч хөрш орон”-ууд, олон улсын байгууллагуудтай дээд хэмжээний харилцан

*Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын хүрээлэнгийн судлаач

айлчлалуудыг тогтмол хийж өргөн хүрээнд харилцсан байна.

Энэ хугацаанд Монгол Улсын удирдлагууд 20 гаруй удаагийн айлчилал хийжээ. Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ, АНУ (АНУ нь Монгол Улсын “гуравдагч хөрш улс”) зэрэг чухал хөрш орнуудаас гадна зүүн өмнөд азийн Вьетнам, Мьянмар, Сингапур зүүн хойд азийн БНАСАУ европын Польш зэрэг орнуудаар айлчилж, НҮБ-ын 68 дахь удаагийн нэгдсэн хуралдаанд оролцож НҮБ нарийн бичгийн дарга Пан Ги Мун-тай уулзажээ, мөн 44 дахь удаагийн Давосын эдийн засгийн чуулга уулзалт, Кыргызстан Улсын нийслэл Бишкек хотноо болсон ШХАБ гишүүн орнуудын удирдагч нарын 13-р дээд хэмжээний уулзалт, БНХАУ-ын Шанхай хотноо болсон Ази Тивд итгэлцлийг бэхжүүлэх 4-р удаагийн уулзалт зэрэг олон улсын чухал хуралдаануудад оролцсон байна. Ерөнхий сайд Н. Алтанхуяг БНХАУ, ОХУ, Япон улсуудад айлчилж БНХАУ Чэн Дү хотод болсон 14-р удаагийн Хятадын баруун бүсийн олон улсын үзэсгэлэнгийн нээлтийн ажиллагаа, 6-р удаагийн Хятадын баруун бүсийн олон улсын хамтын ажиллагаа чуулга уулзалт, ОХУ-ын Санкт-Петербург олон улсын байгууллагын чуулга уулзалтанд оролцсон байна. Мөн Женевийн 103 дахь удаагийн олон улсын хөдөлмөрчдийн байгууллагын хуралд оролцож “ажлын байрны хөгжил дэвшил-ажлын байр 2014” сэдэвтэй илтгэл таьсан байна: УИХ дарга З. Энхболд БНХАУ, АНУ, БНСУ-д айлчилж, Женев хотноо болсон олон улсын парламентын холбооны 129-р удаагийн олон улсын чуулга уулзалтанд оролцсон байна: Монгол Улсын шадар сайд, УИХ-ын дэд дарга, гадаад харилцааны сайд, батлан хамгаалахын сайд зэрэг өндөр албан тушаалтнууд холбогдох улс орнуудад олон удаагийн айлчилуудыг хийсэн байна.

Үүний зэрэгцээ 20 гаруй улс орны удирдагчид Монгол улсад айлчилал хийсэн байна. Жозе Мануэль Баррозу, Канадын захирагч Дэвид Жонстон, тухайн үеийн БНХАУ-ын ардын их хурлын дарга Ү Бан Гуо, Япон Улсын ерөнхий сайд Сэнзо Абэ, Польшийн ерөнхийлөгч Бронислав Коморовский, Өмнөд Африкийн дэд ерөнхийлөгч Кгалема Мотланте, тухайн үеийн Тайландын ерөнхий сайд Инлак Чинават, ЕАБХАБ парламентын дарга Рикардо Ми Гели Ори, Беларусь улсын ерөнхий сайд Меясниковч, БНСУ парламентын дарга Мьянмарын парламентын дарга Турашиман, Латви улсын ерөнхийлөгч Андрис

Берзиньш, Туркын парламентын дарга Жамиль Чичек, ОХУ төрийн думын дарга хадагтай Валентина Матвиенко, АНУ-ын батлан хамгаалахын сайд Хэгель, Францын батлан хамгаалах яамны төлөөлөгчид зэрэг өндөр албан тушаалтнууд Монгол Улсад айлчилжээ.

Монгол Улс олон улсын чухал уулзалт хуралдаанд идэвхитэй оролцохоос гадна өөрийн улсдаа томоохон хэмжээний олон улсын хурлыг зохион байгуулж олон улс өмнө хүлээсэн үүрэгээ биелүүлж байна. 2013 оноос нийслэл Улаанбаатар хотод, 7 дахь удаагийн олон улсын ардчилсан орнуудын чуулга уулзалт, 2013 олон улсын уул уурхайн хөрөнгө оруулагчдын хурал, 32 дахь удаагийн хүнс газар тариалан мал аж ахуйн салбарын ази номхон далайн бүс нутгийн хурал, Монгол Улс НҮБ-тай хамтран зохион байгуулсан “дэлхийн худалдааны байгууллагын худалдааны хэлэлцээг багасгах—далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын нөлөө” сэдэвт олон улсын хурал, “Монгол эрчим хүч 2014” олон улсын хурал болон 2-р удаагийн олон улсын эрчим хүчний хурал, “мэдрэмжтэй үнэ, цогц үйлчилгээг үзүүлэх нь” сэдэвтэй Монгол Улсын зам тээвэрийн олон улсын хурал, “Улаанбаатарын яриа хэлэлцээ” 1-зэрэг уулзалт хурлууд хийгдсэн байна. Монгол Улс 2015 оны ази номхон далайн хүний эрхийн олон улсын семнаарыг зохион байгуулах юм.

Монгол Улсын гадаад улс орнуудтай дипломат харилцаа тогтоох үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байна. УИХ-ын 02-10 дугаар шийдвэрээр Монгол Улс 2013 оноос Антигуа Барбуда, Бурунди, Вануату, Палау, Суринам, Сьерра-Леоне, Того, Эритрей, Ямайк, Гайти, Чад зэрэг улсуудтай дипломат харилцаа тогтоож элчин сайдын төвшиний гадаад харилцаатай болсон бөгөөд одоогийн байдлаар Монгол Улс 175 оронтой дипломат харилцаа тогтоогоод байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал, засгийн газрын 2012-2016 оны хөтөлбөрт тусгагдсан зорилтын дагуу НҮБ-д Монгол Улстай дипломат харилцаа тогтоогоогүй байгаа улс орнуудтай дипломат харилцаа тогтоох үйл ажиллагааг

1. “Улаанбаатарын яриа хэлэлцээ” бол Монгол Улсын ерөнхийлөгч ц.Элбэгдорж “Хельсинкийн үйл явц”-ыг хуулбарласан хувилбар бөгөөд 2013 оны 4 сард Монгол Улсад болсон 7-р удаагийн ардчилсан орнуудын парламентын дарга нарын уулзалтын үеэр анх дэвшүүлэн тавьсан юм. Монгол Улс нь зүүн хойд азийн улс орнуудтай сайн харилцаатай байдаг учраас уг яриа хэлэлцээрээр дамжуулан бүс нутагт тулгараад байгаа аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх зорилготой —зохиолч

явуулж байна. 2010 оны 12 сарын 30 эхлэн Монгол улс НҮБ дахь өөрийн төлөөлөгчөөрөө дамжуулан Монгол Улстай дипломат харилцаа тогтоогоогүй байгаа НҮБ-ын 45 улстай дипломат харилцаа тогтоох хүсэлтээ илгээсэн байна. Одоогоор уг 45 ороноос 18-тай нь дипломат харилцаа тогтоогоод байна. Үлдсэн 27 оронтой 2014 ондоо багтаан дипломат харилцаа тогтоохоор ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын задгай тор шиг гадаад харилцаа ихээхэн үр дүнгээ өгч сүр дуулиантай газар сайгүй найзуудтай болж байна, ялангуяа Монгол Улсын “гуравдагч хөрш орон”-нууд болох Европын холбоо, НАТО, АНУ, Япон, Солонгос зэрэг улс орон олон улсын байгууллагуудтай харилцах харилцаа улам ойртож байгаа нь Монгол Улсын олон улс дахь нөлөө дээшилсээр байгааг харуулж байна. Гэхдээ Монгол Улсын төрийн гурван өндөрлөгүүд болох ерөнхийлөгч, ерөнхий сайд, УИХ-ын дарга нар БНХАУ, ОХУ-д дээд хэмжээний айлчлал олон хийсэн нь гадаад харилцааны гол тулгуур хоёр хөрш орон нь хэвээрээ байгааг харуулж байна, энэ нь <<Монгол Улсын гадаад харилцааны үзэл баримтлал>>-д ОХУ, БНХАУ бол Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл мөн гэсэн заалттай нийцэж байгаа юм.

(2) Монгол Улсын гадаад харилцааны тэргүүлэх чиглэл бол БНХАУ, ОХУ юм.

Газар зүйн байрлалын хувьд зөвхөн БНХАУ, ОХУ-тай хилэлдэг Монгол Улс оршин тогтнох болон цаашдын хөгжлийн хувьд Хятад, Орос улстай салшгүй холбоотой юм. Монгол Улс энэ байдлыг хатуу мэдэж учраас хуулийн хэлбэрээр баталгаажуулж² Орос Хятадтай харилцах харилцааг тэргүүлэх чиглэлээ болгон сайн хөршийн найрсаг харилцаатай байна. Монгол Улс 2009 он, 2011 онуудад хоёр хөрштэйгөө стратегийн түншлэлийн харилцаа байгуулсан бөгөөд эдийн засгийн хувьд Хятад, Орос улсуудтай бүр ч салшгүй холбоотой байгаа юм. Гэхдээ түүхийн асуудал болон геополитикийн харилцаанаас шалтгаалан Хятад, Орос улсаас болгоомжилж байдаг бөгөөд харилцан адилгүйгээр хардаж сэрддэг байна. Монгол Улсын хүчин чадал Хятад Орос улсуудаас

2. 2011 оны 2 сард Монгол Улсын их хурал “Монгол Улсын гадаад харилцааны үзэл баримтлал”-д шинээр нэмэлт өөрчилөлт оруулж ОХУ,БНХАУ нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын тэргүүлэх чиглэл хэмээн тодорхой заасан байна.

харьцангуй доогуур учраас аль нэг улсынх нь эсвэл тус хоёр улсын хамжлага улс болохоос болгоомжилж байдаг юм. Тиймээс Монгол Улс ардчилсан хувьсгал хийснээс хойш “гуравдагч хөрш улс”-ыг хайх болсон юм, уг “гуравдагч хөрш улс” гэдэг нь газар нутгаар холбогдсон биш харин улс төр, цэрэг, эдийн засгийн харилцаагаар холбогдсон бөгөөд гуравдагч хөрш оронтой болсноор Монгол Улс нь өөрийн олон улс дахь стратегийн тулгуурыг нэмэгдүүлж, аюулгүй байдал тусгаар тогтнолыг баталгаажуулах юм. Үүний зэрэгцээ талуудаас улс төр эдийн засгийн ашиг олж өөрийн улсын олон улс дахь байр суурийг дээшлүүлэх юм. Монгол Улсын харж байгаагаар дэлхий дээр Хятад Оросын нөлөөг тэнцвэржүүлж чадах улс нь одоогоор АНУ³, тиймээс Монгол Улс АНУ зэрэг барууны орнуудтай харилцаагаа улам ойртуулж Афганистан, Ирак дахь цэргийн ажиллагаанд цэрэгээ явуулж оролцуулсан юм, 2012 оны 5 сард “энх тайванч даяр түнш”-ийн хувиар НАТО-гын дээд хэмжээний хуралд оролцож 2012 оны 11 сард ЕАБХАБ-т (Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага) элсэн оров. Монгол Улсын “гуравдагч хөрш улс” гэдэг нь нэг улс биш, харин АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, Өмнөд Солонгос, Турк зэрэг барууны орнууд, зүүн азийн орнууд болон олон улсын байгууллагууд юм.

Үнэндээ Монгол Улс АНУ зэрэг “гуравдагч улс орон”-уудтай ойртож, АНУ тэргүүтэй НАТО болон ЕАБХАБ-т элсэн орсноор Монгол Улс НАТО-гын шатрын хүү болж Хятад Оросыг хязгаарлаж тэнцвэржүүлэнэ гэсэн үг биш юм. Монгол Улс ч тийм хялбархан аль нэг талыг барьж туулширсан харилцааг сонгохгүй. Монгол Улс Хятад Орос улсуудтай мөнхийн хөрш орон гэдэгээ тодорхой мэдэж байгаа учраас Хятад Орос, “гуравдагч хөрш улс”-уудын дунд төвийг сахисан харилцааг баримтлана. Бодит байдал дээр Монгол Улс хоёр хөрш оронтойгоо эртнээс цэрэг аюулгүй байдлын хамтын ажиллагааг тогтмолжуулсан байна. Хятад Монгол улсын батлан хамгаалах аюулгүй байдлын зөвөлгөөнийг Бээжин Улаанбаатар хотод ээлжлэн зохион байгуулж, хоёр тал хамтарсан сургалт, хилийн харилцаа, энхийг сахиулах үйл ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдал зэрэг

3. Зохиолч Ц.Батбаяр: “1990-ээд оны олон улсын харилцаа, Монгол Улс болон их гүрнүүдийн харилцаа” 90-р хуудас (О.Отгон: “90-ээд оны Монгол Америкийн харилцаа”), 1995, Улаанбаатар

асуудлаар байнга харилцан саналаа солилцдог бөгөөд хоёр талын цэргийн өндөр албан тушаалтны уулзалтыг тогтмол байлгах талаар тохиролцжээ. Монгол Оросын цэргийн салбарын харилцаа илүү дотно байдаг ба ОХУ нь Монгол улсад их хэмжээний цэргийн тусламж үзүүлж жил бүр цэргийн хамтарсан сургууль тогтмол хийдэг байна. Тиймээс Монгол Улс холын хөршөө холбоотон болгож ойрын хөршөө дайсан болгох алхам хийхгүй харин хол хөрштэйгөө харилцаж ойрын хөрштэйгөө дайсагнахгүй байх нь Монгол Улсын зайлшгүй баримтлах гадаад бодлого байна. Энэ бол жижиг улсын гадаад бодлогын ерөнхий хандлага билээ.

2. Монгол Улс ба Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)

Монгол Улс нь ШХАБ-ын анхны ажиглагч орон бөгөөд ШХАБ-ын ажиглагч орондоо нээлттэй төрөл бүрийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож ирсэн юм, сүүлийн хоёр жил ШХАБ-тай харилцах асуудлыг улам илүү чухалчилан үзэж байгаа хандлага ажиглагдаж байна.

Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2012 оны 6 сард Бээжин хотноо болсон ШХАБ-ын удирдагч нарийн зөвлөлийн 12-р хуралд оролцсоны дараа 2013 оны 9 сард Кыргызстан улсын нийслэл Бишкек хотноо болсон ШХАБ-ын удирдагч нарийн зөвлөлийн 13-р хуралд дахин ирж оролцсон байна. Харин 2011 оны 6 сард Казакстан Улсын Астана хотод болсон ШХАБ-ын удирдагч нарийн зөвлөлийн 11-р хуралд Монгол Улс ердөө ерөнхийлөгчийн ажлын албаны даргыг л хуралд томилон оролцуулсан байсан нь айлчлалын зэрэглэл харьцангуй доогуур байсныг илтгэж байна. 2013 оны 11 сарын 28-29 өдөр Узбекистан улсын Ташкент хотод болсон ШХАБ-ын гишүүн орнуудын засгийн газрын тэргүүн нарийн зөвлөлийн 12-р хурал болсон. Уг хуралд шинээр нэмэгдсэн Афганистан зэрэг 5 ажиглагч орон төлөөлөгчдөө явуулж оролцуулсан, Монгол Улсаас шадар сайд Д. Тэрбишдава, Энэтхэг улсаас гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга Сүжата, Иран улсаас үйлдвэр уул уурхай худалдааны яамны сайд Нематжед, Пакистан улсаас ерөнхий сайдын аюулгүй байдал гадаад бодлогын зөвлөх Ажиц, Афганистан улсаас

хоёрдугаар дэд ерөнхийлөгч Халили нар хуралд хүрэлцэн ирсэн байна. Ажиглагч орнуудын томилон ирүүлсэн төлөөлөгчдийн зэрэглэлээс харахад Монгол Улсын төлөөлөгчийн зэрэглэл хамгийн өндөр байна. Хуралд оролцож байгаа төлөөлөгчдийн зэрэглэлээс харахад сүүлийн хоёр жил Монгол улс ШХАБ-тай харилцах харилцаандаа илүү анхаарч байна. Монгол Улсын төлөөлөгч ШХАБ-ын бүх төрлийн хуралдаануудад оролцсноор уг байгууллагын шинэ нөхцөл байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ өөрийн улсын оролцох хүрээ хэмжээг мэдэж авахаас гадна хурлын далимаар холбогдох улс орнуудтай хоёр талын уулзалтуудыг хийж харилцан итгэлцэл хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой юм. 2013 оны 9 сарын 12-нд БНХАУ-ын дарга Си Зинь Пин Бишкек хотноо Монгол Улсын ерөнхийлөгч Ц. Элбэгдоржтой уулзалж хоёр улсын талаар санал бодолоо солилцсон байна. Си Зинь Пин хэлэхдээ, Хятадын тал эртнээс Монгол Улстай харилцах харилцаагаа чухалчилж ирсэн, Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, тугаар тогтнолыг хүндэтгэн үздэг бөгөөд Монголын ард түмний сонгосон хөгжлийн замыг хүндэтгэнэ, Хятадын тал харилцан ашигтай хамтдаа хожих гэсэн зарчмын дагуу Монгол Улстай хамтран ажилладагийг онцлон тэмдэглэв. Хоёр тал уул уурхай, дэд бүтцийн бүтээн байгуулалт, банк санхүүгийн хамтын ажиллагаа зэргийг цогцлуулан хөгжүүлэх, эрх тэгш зарчмын дагуу эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг урагшлуулан бэхжүүлэх, мэдээлэл сүлжээ холбооны томоохон төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой гэсэн байна. Монгол Улсын ерөнхийлөгч Ц. Элбэгдорж хэлэхдээ, Монгол Улс урт хугацааны тогтвортой Монгол Хятадын сайн хөршийн харилцааг хөгжүүлэхийг эрмэлздэг, Хятадын талын хамтран ажиллах зарчим, хөгжлийн үзэл санааг бүрэн дэмжиж байна, манай улс “Уул уурхайд түшиглэсэн хөгжил”-ийн бодлого хэрэгжүүлж байгаа энэ үед Хятад улстай эрчим хүч уул уурхай, худалдаа эдийн засаг, дэд бүтэц зэрэг салбаруудад хамтын ажиллагаагаа илүү сайжируулж том хэмжээний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн хоёр улсын хамтын ажиллагаанд таатай орчин бүрэлдүүлэхийг хүсэж байна гэжээ.

2014 он гарснаас хойш Монгол Улс ШХАБ-ын үйл ажиллагаанд үргэжлүүлэн идэвхитэй оролцож байна. 2014 оны 1 дүгээр сарын 21-22-нд Москва хотод болсон ШХАБ-ын бүс нутгийн аюулгүй байдал

асуудлаар хэлэлцүүлэгт Монгол Улсаас Афганистан улсад суугаа элчин сайд О. Дамбиням тэргүүтэй төлөөлөгчдийг томилон оролцуулсан юм. Хурлын үеэр Дамбиням сайд Монголын талын байр суурийг тодорхой илэрхийлэв. Тэрээр, Монгол Улс Ази тивийн аюулгүй байдал эдийн засаг, улс төрийн тогтвортой эрхэмлэн дээдлэж сахин хамгаалахсаар ирсэн бөгөөд Монгол улсын цэрэг Афганистан улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд олон жил идэвхитэй оролцож байгааг онцлон дурдсан юм. Мөн Монгол Улсын ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн дэвшүүлсэн “Зүүн хойд азийн аюулгүй байдал Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г танилцуулж хуралд оролцогчдыг удахгүй болох “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-д идэвхитэй оролцохыг уриалсан байна. 2014 оны 4 сарын 26-нд Бээжин хотноо болсон ШХАБ-ын гишүүн орон болон ажиглагч орнуудын төлөөлөгчдийн “6+5”-ын хуралд Монгол Улсын Гадаад хэргийн яамны хөрш орнуудын газрын дарга Т. Төгсбилгүүн оролцсон юм. ШХАБ-ын нарийн бичгийн дарга Дмитрий Мезенцев уг хурлыг даргалсан бөгөөд хурлаар ШХАБ ажиглагч орнуудтайгаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой байгаа илэрхийлж, салбар бүрийн хамтын ажиллагааг урагшлуулан хөгжүүлэх талаар санал бодолоо солилцсон байна. Монгол Улс ШХАБ-ын ажиглагч орны хувьд хамтарч ажиллаж болох салбар бүрт идэвхитэй оролцохоо илэрхийлсэн юм.

Монгол Улс ШХАБ-т чухал ач холбогдол өгч байгаа нь ШХАБ-ын анхааралыг татаж байна. 2014 оны 3 сарын 24-нд ШХАБ-ын нарийн бичгийн дарга Дмитрий Мезенцев Монгол Улсад айлчлал хийсэн юм. Дмитрий Мезенцев Монгол Улсын гадаад хэргийн сайд Л.Болдтой уулзах үеэрээ ШХАБ-ын үйл ажиллагаа цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийн танилцуулж ШХАБ-ын гишүүн орнууд тэр дундаа Монгол Улстай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна. Болд сайд хэлэхдээ, Монгол Улс бүс нутгийн улс төр эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцдог, ажиглагч орны хувьд ШХАБ-ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож тус байгууллагатай илүү өргөн хүрээнд хамтран ажиллах сонирхолтой байгаа гэдэгээ илэрхийлсэн байна. Мөн тэрээр бүс нутгийн аюулгүй байдлыг бий болгоход эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийн чухалыг онцлон тэмдэглэсэн байна.

Дээрх Монгол Улс ШХАБ-ын хоорондох идэвхитэй үйл ажиллагаанаас Монгол Улс тус байгууллагыг илүү их чухалчилж ихээхэн итгэл найдвар тавьж байгаа нь харагдаж байна. Монгол Улсын төрийн албан тушаалтан судлаач шинжээч хэвлэл мэдээлэлийн хэрэгслийн мэдээлэлүүдийг ерөнхийлөн авч дүгнэхэд, Монгол Улс ШХАБ-ын цаашдын хөгжил Монгол Улсын оролцооны талаар доорх хэдэн саналыг дэвшүүлж байна:

1. Монгол Улс ШХАБ-ын ажиглагч орон болсон 10 жилийн хугацаанд ажиглагч орны үүрэгээ бүрэн биелүүлсэн. Монгол Улсын дотоодод ШХАБ-ын тэмцдэг олон улсын терроризм, шашины хэт үзэл, салан тусгаарлагч зэрэг “3 хар хүч”-ний аюул байхгүй учраас Монгол Улс ШХАБ-тай эдийн засгийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр эрэлхийлж байгаа юм, Монгол Улс бүс нутгийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, байгаль хамгаалал зэрэг салбарт хамтран ажиллах сонирхолтой байна. Гэвч одоог хүртэл ШХАБ-ын эдийн засгийн хамтын ажиллагаанд төдийлөн ахиц гараагүй байна. Тиймээс ШХАБ-ыг ажиглагч орнууд болон түнш орнуудын гишүүн орнуудтай явагдах эдийн засгийн интеграцийн асуудлыг шийдвэрлэхийг хүсэж байна.

2. ШХАБ-ын гишүүн орнуудын засгийн газрын тэргүүнүүдийн Ташкент хотод болсон хурлаар зам харилцааны салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх хамтарсан мэдэгдэл гаргаж, гишүүн орнуудын холбогдох газрууд зам харилцааны салбарын харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх алхам хийх шийдвэр гаргасныг Монгол Улс дэмжиж байгаа юм. ШХАБ-ын ерөнхий сайд нарын дэвшүүлсэн “ажиглагч орнуудын болон харилцан ярианы түншүүдтэйгээ хамтын ажиллагааг хөгжүүлэж, эдгээр орнуудыг зам харилцааны салбарын хамтын ажиллагаандаа татан оролцуулах нь чухал” гэсэн саналыг Монгол Улс талархан хүлээж авч байгаа юм. Монгол Улсыг дайруулан өнгөрөх төмөр зам, авто зам, дамжуулах хоолой зэрэг ажлуудад Монгол улс Орос Хятад улсуудтай идэвхитэй хамтран ажиллах сонирхолтой байгаа ба эдгээр салбарын хамтын ажиллагаагаар дамжуулан ШХАБ-ын гишүүн орнууд болон ажиглагч орнуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх хүсэлтэй байгаа юм.

3. Монгол Улс ШХАБ-ын холбогдох газруудаас 2010 оны 1 сард Улаанбаатар хотноо болсон ШХАБ-ын бизнесийн зөвөлгөөн чуулга уулзалтын үеэр дэвшүүлсэн ажиглагч орнуудтай хамтын ажиллагааг сайжруулах, бүс нутгийн аялал жуулчлалын хамтын ажиллагааг урагшлуулах зэрэг саналыг ажил хэрэг болгохыг хүсэж байна. Монгол Улс хэрвээ уг байгууллагын хүрээндэх хил дамжсан аялал жуулчлалын хамтын ажиллагаанд оролцож чадвал өөрийн улсын “уул уурхай, аялал жуулчлал, мал аж ахуй” гэсэн гурван биет нэг цогц эдийн засгийг хөгжүүлэхэд тустай юм.

4. Монгол Улс нь ШХАБ-ын анхны ажиглагч орон, мөн түүнчлэн ШХАБ-ын хүрээнд бүх талуудаас хүлээн зөвшөөрөгдсөн улс юм. Тэгвэл Монгол Улс анхны ажиглагч орноос албан ёсны гишүүн орон болж болох болов уу. 10 гаруй жилийн турш Монгол Улс ШХАБ-ын гишүүн болох асуудлыг албан ёсоор дэвшүүлж байгаагүй. Гэхдээ сүүлийн жилүүдэд Монгол Улсын ШХАБ-т хандаж байгаа нааштай хандлагаас дүгнэхэд Монгол Улс ШХАБ-тай харилцах харилцаагаа дээшлүүлэх сониролтой байна. Хэрвээ уг байгууллага бүс нутагтаа эдийн хамтын ажиллагааны алхамуудыг хурдтай явуулбал Монгол Улс тус байгууллагат элсэн орох асуудлыг бодолцож болох юм. Монгол Улсын ШХАБ-ын асуудал эрхэлсэн мэргэжилтний хэлснээр, Монгол Улс ШХАБ-т элсэн орох асуудлыг судлаж байна гэлээ.